



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ШААРДЛАГА

ХЯЛБАРШУУЛСАН ХУВИЛБАР

2026 он




Өмнөх үг

2006 оны 8 дугаар сард МУУҮА-ийн Зөвлөлийн хурлаар Монгол Улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилгыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Улмаар Азийн сангийн дэмжлэгтэйгээр төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, бизнесийн байгууллагууд, судлаачдыг хамарсан оролцогч талуудын уулзалтуудыг зохион байгуулж, уг асуудлыг хэлэлцэн, хариуцлагатай уул уурхайн үзэл санаа,

эрхэм зорилго, тодорхойлолт, үйл ажиллагааны зарчмуудыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Тухайн оны 12 дугаар сард хуралдсан МУУҮА-ийн бүх гишүүдийн хурлаар Ассоциацийн дүрэмд өөрчлөлт оруулж, **“МУУҮА-ийн эрхэм зорилго нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарт хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйл хэрэгт идэвхтэй оролцож...”** хэмээн тодорхойлсон.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН КОДЕКСИЙН ТҮҮХЭН ТОВЧООН



2. Үндэслэл

Энэхүү “кодексийн” үзэл баримтлал нь 2007 онд оролцогч талуудын тодорхойлсон “Монголын хариуцлагатай уул уурхай нь эрдэс баялгийн салбарын үйл ажиллагааг тодорхойлогч стандарт мөн” хэмээх хариуцлагатай уул уурхайн үзэл санаа, түүнчлэн “Монголын нийт ард түмэн хариуцлагатай уул уурхайн үзэл санааны дор энэ салбарын талаарх үнэн бодит мэдлэг, мэдээлэлтэй болох, улмаар харилцан санал бодлоо солилцох орон зайг бий болгох явдал юм” гэсэн хариуцлагатай уул уурхайн эрхэм зорилго, мөн үйл ажиллагааны 8 зарчимд суурилсан.

Түүнчлэн энэхүү шаардлагыг боловсруулахдаа Канадын Уул уурхайн ассоциацийн “Тогтвортой Уул уурхайн төлөө” буюу “TSM” (Towards Sustainable Mining) хөтөлбөрийн хэрэгжилтын загвар, арга барилыг харгалзан үзсэн болно.

Хариуцлагатай уул уурхайн кодексийг нэвтрүүлж хэрэгжүүлэх нь тухайн байгууллагын ерөнхий гүйцэтгэлийг сайжруулах, тогтвортой хөгжлийн санаачилгыг дэмжих, нээлттэй ил тод зарчмыг баримтлах, мөн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж буй ажлыг дэмжих зорилготой тул байгууллагын хувьд стратегийн шийдвэр хэмээн үзэж байна.

Энэхүү кодексийг нэвтрүүлснээр байгууллага дараах ашиг тусыг хүртэх боломжтой. Үүнд:



иргэд, олон нийтийн
итгэлийг олж авах, хадгалах;



хууль тогтоомжийн
шаардлагад нийцүүлэн үйл
ажиллагаагаа явуулах;



байгууллагын нэр хүнд,
үнэлэмж дээшлэх;



байгууллагын стратегийн
зорилтуудтай холбоотой
эрсдэл, боломжуудыг
тодорхойлон авч үзэх;



үйл ажиллагааны урт
хугацааны тогтвортой
байдал хангагдах,

Энэхүү кодексст менежментийн тогтолцооны Төлөвлөг-Гүйцэтгэ-Шалга-Сайжруул (ТГШС) мөчлөг болон эрсдэлд суурилсан сэтгэлгээг хослуулсан үйл явцын арга барилыг хэрэглэсэн болно. Мөн стандарт нь одоогийн

үйл ажиллагаанд нэмэлт дарамт болохгүйгээр хэрэгжилтийг хангах боломжийг бүрдүүлсэн бөгөөд маш ойлгомжтой, ачаалал багатай нь давуу тал болно.

3. Нэр томьёо ба тодорхойлолт



Өгүүлбэр эсвэл илэрхийлэл нь “...на, ...нэ,...но,...нө” гэж төгссөн тохиолдолд заавал биелүүлэх шаардлагыг; харин “...зохино” гэж төгссөн тохиолдолд зөвлөмжийг тус тус илэрхийлнэ.

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ ГЭЖ

Бүх холбогдох талууд, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурласан, хууль дээдлэх ёсыг хүндэтгэсэн, Монгол Улсад байнгын ашиг орлого оруулж буй эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг ойлгоно.

Тайлбар: “Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэх тунхаг”-т тодорхойлсон

ИЛ ТОД БАЙДАЛ ГЭЖ

Үйл ажиллагаа, шийдвэр, үйл явц нь тодорхой, хүртээмжтэй, бусдын өмнө эгэх хариуцлагатай байх нөхцөлийг хангах үйлдвэрлэл, үйлчилгээг ил тод явуулах дадал

ҮЙЛ ЯВЦ ГЭЖ

Төлөвлөсөн үр дүнд хүрэхийн тулд оролтуудыг ашигладаг харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэл бүхий үйл ажиллагаануудын багц

Тайлбар: MNS ISO 9000:2016 Үндсэн ухагдахуун ба нэр томьёо тодорхойлолт

МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ГЭЖ

Бодлого ба зорилтуудыг хангах үйл явцуудыг тогтооход чиглэсэн байгууллагын харилцан хамааралтай эсвэл харилцан үйлчлэлтэй элементүүдийн багц

ШААРДЛАГА ГЭЖ

Тогтоосон, нийтээр зөвшөөрсөн эсвэл заавал биелүүлэх хэрэгцээ ба хүлээлт

Тайлбар: MNS ISO 14001:2016

АЮУЛ ГЭЖ

Гэмтэл ба/эсвэл эрүүл мэндийн хохиролд хүргэж болох эх үүсвэр

Тайлбар: MNS ISO 45001:2018

1. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХЭМАБ) эрсдэл гэж
2. Хүний бие махбод, мэдрэл сэтгэхүй, оюун ухаанд үзүүлэх сөрөг нөлөө

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ТАЛБАР ГЭЖ

Орчинтой харилцан үйлчилдэг, байгууллагын үйл ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний элемент

Тайлбар: MNS ISO 14001:2016

ОРОН НУТАГ ДАХЬ СОНИРХЛЫН БҮЛГҮҮД ГЭЖ

Байгууллагын шийдвэр эсвэл үйл ажиллагаанд нөлөөлж болох, нөлөөнд автаж болох, мөн өөрийгөө нөлөөнд автана гэж төсөөлж буй хувь хүн, бүлэг, байгууллага

4. Хамрах хүрээ ба шаардлагын бүрэлдэхүүн

Хариуцлагатай уул уурхайн шаардлага нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна. Үүнд:



5. Хариуцлагатай уул уурхайн зарчмууд

Энэхүү кодекс нь 2007 онд оролцогч талуудын тодорхойлсон хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааны дараах зарчмууд дээр суурилсан болно. Үүнд:



Тайлбар: “Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэх тунхаг”-т тодорхойлсон

6. Шаардлага

6.1 ЕРӨНХИЙ ШААРДЛАГА



- 6.1.1 Бодлого нь баримт бичгээр баталгаажсан ба хамаарал бүхий талуудад танилцуулсан, сонирхогч талуудад хүртээмжтэй байна.
- 6.1.2 Зорилтууд нь баримт бичгээр баталгаажсан бөгөөд тодорхой, биелэгдэхүйц, хэмжигдэхүйц байна.

6.2 КОМПАНИЙН САЙН ЗАСАГЛАЛ БА ИЛ ТОД БАЙДАЛ



- 6.2.1 Мэдээллийн ил тод байдлыг хангах бодлоготой байна.
- 6.2.2 Бодлого хангах зорилтуудаа тогтоож, төлөвлөж хэрэгжүүлнэ.
- 6.2.3 Санал гомдол авах, түүнийг шийдвэрлэж, эргэн мэдээлэх үйл явцтай байна.
- 6.2.4 Хууль тогтоомжийн шаардлага болон холбогдох бусад шаардлагыг тодорхойлж нийцлийн үнэлгээ хийсэн байна.
- 6.2.4 Авлигын эсрэг бодлоготой байвал зохино.

6.3 ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА БА ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХ



- 6.3.1 Ажилтны эрхийг хүндэтгэсэн, жендэрийн эрх тэгш байдал болон бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх бодлоготой байна.
- 6.3.2 Бодлогыг хэрэгжүүлэх зорилтуудыг тогтоож, төлөвлөж, хэрэгжүүлнэ.

6.4 ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ



- 6.4.1 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын (ХЭМАБ)-ын эрсдэл ба боломжуудын онцлог шинж чанарт тохирсон ХЭМАБ-ын бодлоготой байна.
- 6.4.2 ХЭМАБ-ын зорилтуудыг тогтоож, төлөвлөж, хэрэгжүүлнэ.
- 6.4.3 Аюул олж илрүүлэх үйл явцыг бий болгосон байна.
- 6.4.4 Аюултай холбоотой эрсдэлийг тодорхойлж, эрэмбэлсэн байна.
- 6.4.5 ХЭМАБ-ын эрсдэл, боломжид чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

6.5 ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ



- 6.5.1 Хүрээлэн байгаа орчны талаарх бодлогоо тодорхойлсон байна.
- 6.5.2 Хүрээлэн байгаа орчны талаарх зорилтуудыг тогтоож, төлөвлөж хэрэгжүүлнэ. Нөлөөлөл болон түүнтэй холбоотой эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээ хийдэг байна.
- 6.5.3 Эрсдэлд суурилсан арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

6.6 ОРОН НУТГИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА



- 6.6.1 Орон нутаг дахь сонирхлын бүлгүүдийг тодорхойлсон байна.
- 6.6.2 Сонирхлын бүлгүүдтэй үр нөлөөтэй харилцах үйл явц бүрдүүлсэн байна.
- 6.6.3 Орон нутгийн харилцаа хариуцсан ажилтантай байна.



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ШААРДЛАГА

ХЯЛБАРШУУЛСАН ХУВИЛБАР

Энэхүү гарын авлагыг “Эрдэс баялгийн менежментэд шударга байдлыг бэхжүүлэх-Интегра Санаачилга” төслийн санхүүжилтээр Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн хэрэгжүүлж буй “Жижиг дунд компаниудад зориулсан Хариуцлагатай уул уурхайн кодекс” тэтгэлэгт төслийн хүрээнд боловсруулав.

Гарын авлагад тусгагдсан агуулга, дүгнэлтүүд гүйцэтгэгч байгууллагын байр суурийг илэрхийлж байгаа бөгөөд төслийг санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн байр суурийг илэрхийлээгүй болно.

-  www.miningmongolia.mn
-  Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци
-  Mongolian National Mining Association
-  @miningmongolia
-  @mongolian_mining_association
-  Info@miningmongolia.mn
-  +976 7011 0163